



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

9093 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 4/309

Мандалговь

Үзлэг, шалгалт явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.4, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.6.4, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, Батлан хамгаалахын сайдын 2017 оны A/331 дүгээр тушаалаар батлагдсан Цэргийн бүртгэл явуулах журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын 18-50 насны цэргийн бэлтгэл үүрэгтэн, бэлтгэл офицеруудын цэргийн үүргийн биелэлтийн үзлэг, хяналт шалгалтыг 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж явуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (дэд хурандаа Θ.Баясгалан)-т үүрэг болгосугай.

2. Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Θ.Баясгалан (Цэргийн дарга, дэд хурандаа)

Гишүүд: Г.Цэрэндолгор (Тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа)

Ц.Баттулга (Орон нутгын Хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер, дэд хурандаа)

3. Хяналт шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын нэрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалгаж, үзлэгт бүрэн хамруулж илэрсэн зөрчлийг арилгуулах, Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөх төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллах, хяналт шалгалт явуулсан тухай дүнг нэгтгэн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны дотор танилцуулсугай.

5. Дээрх хуулиудын хэрэгжилтийг зөрчсөн албан байгууллага болон цэргийн үүрэгтнүүдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэн ажиллахыг комиссын дарга (дэд хурандаа Θ.Баясгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

4823100546

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын
04-ны өдрийн 04 дүгээр захирамжийн хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫГ ТӨРИЙН БОЛОН
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙХ ХУВААРЬ**

Дд	Оролцох байгууллагууд	Үзлэг, шалгалт хийх хугацаа	Тайлбар
1	Бүх сумдын төрийн болон төрийн бус байгууллагууд	II, III улиралд	
2	"МХС" ТӨК	II, III улиралд	
3	МЦХ" ХХК	II, III улиралд	
4	Шуудан үйлчилгээний газар	II, III улиралд	
5	БЗӨБ-ийн Дундговь аймгийн цахилгаан түгээх сүлжээ	II, III улиралд	
6	Дундговь аймгийн цахилгаан дамжуулах сүлжээ	II, III улиралд	